

**МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022. оны 10. сарын 07. өдөр

№ А/87

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 122, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсад цоо шинээр бүрэлдэн бий болж буй нефть-химийн салбарт нарийн мэргэжлийн, өндөр төвөгшилтэй, цогц үйл ажиллагааг явуулж буй компанийн хувьд нийт ажиллагсдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, мэдээллийн болон технологийн аюулгүй байдлыг хангах үүднээс “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дараах зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулсугай. Үүнд:

- 4.4 дэх заалтад “Ажилтан нь үйлдвэрийн технологийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.” гэсэн өгүүлбэр нэмэх;

- 6.2 дахь заалтад “6.2.13. Ажилтан нь Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай саналыг 3 сарын өмнө урьдчилж бичгээр гаргах бөгөөд шинэ ажилтан томилогдох, дадлагжихад дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалт нэмэх;

- 8.1 дэх заалтад “8.1.7. Ажилтан нь ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ үйлдвэрийн болон хотноны талбайд гүйцэтгэх тохиолдолд Хавсралт 1-д заасны дагуу зөвшөөрөл авна” гэсэн заалт нэмэх;


2. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, компанийн ажилтнууд Дорноговь аймагт удаан хугацаагаар ажиллах шаардлагатай болсонтой холбогдуулан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.7 дахь заалтыг дор дурдсан агуулгаар өөрчилсүгэй:

- “11.7. Үйлдвэрийн талбайд ажиллаж буй ажилтанд нэг өдрийн 25,000.00 (хорин таван мянга) төгрөгийн нэмэгдэл олгоно.”

3. Хөдөлмөрийн дотоод журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг нийт ажилтан, албан хаагч наарт танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргааны газар (О.Энхбаяр), Хүний нөөцийн хэлтэс (Х.Оюунцэцэг)-т тус тус даалгасугай.

4. Хөдөлмөрийн дотоод журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тушаал батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.АЛТАНЦЭЦЭГ



“МГТБҮ ТӨХХК-ийн Хөдөлмөрийн дотоод
журам”ын хавсралт1.....

ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙД АЖИЛЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

1	Ажиллах газар (доогуур нь зурах)	Үйлдвэрийн талбай / Хотхоны талбай
2	Хугацаа	202..... оны-р сарын --р сарын-ний өдрүүд
3	Ажиллах бүрэлдэхүүний нэрс	1. 2. 3. 4. 5.
4	Гүйцэтгэх ажлын жагсаалт	1. 2. 3. 4. 5.
5	Замын зардал	Галт тэрэг, хот хоорондын тээвэр, шатахуун

Тайлбар:

- Үйлдвэрийн талбайд ажилласан ажилтанд 1 өдрийн 25,000 төгрөгийн нэмэгдлийг сарын эцэст цагийн бүртгэлийг үндэслэн тооцож олгоно.
- Энэхүү зөвшөөрөл, бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдлийг үндэслэн СЭЗГ-ын дарга замын зардлыг олгоно.
- Ажилтан нь орон нутаг дахь төлөөлөгчид ажилласан хоног, ирсэн/явсан цагийг бүртгүүлнэ.

Зөвшөөрсөн:

Гүйцэтгэх захирал: (.....)

Захиргааны газрын дарга: (.....)

Санхүү, эдийн засгийн газрын дарга: (.....)

Нэгжийн дарга: (.....)